



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 05 өдөр

Дугаар A/552

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер
хүчингүй болгож шууд гэрээ байгуулах
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3, 30 дугаар зүйлийн 30.1.1, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 101 дүгээр дүгнэлтийн дагуу Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлын 14 дүгээр багц Нийтийн эзэмшлийн талбайд ус үл нэвтрэх доторлогоотой нүхэн бие засах газар байгуулах ажлыг 50000000 (тавин сая) төгрөгөөр Онги-Ус суваг ОНӨААТҮГазраар, 15 дугаар багц Пүрэвдоржийн цэцэрлэгт хүрээлэн, Аюуш баатарын хөшөөний тохижилтыг 50000000 (тавин сая) төгрөгөөр Баяннайман ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн усалгааны тоног төхөөрөмж нийлүүлэх багцыг хүчингүй болгосугай.

4. Дээрх хүчингүй болсон багцыг техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэн үнийн харьцуулалт хийж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100996